

**БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ГАЗРЫН ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН ГОТОВ ОВОГТОЙ СҮРЭНЦЭЦЭГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “ЗГҮАХ-ийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.3-28 ”							
1.	Арга хэмжээ 1. Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдийн санал, гомдол, хэрэгцээг үндэслэн дугаарын хязгаарлалтгүй зорчих зөвшөөрөл олгох талаар холбогдох байгууллагад уламжлах, шийдвэрлүүлэх	Хамрагдсан иргэний тоо; Хүсэлт гаргасан албан бичгийн тоо;	600 10	200 10	Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.6-д “Байнгын асаргаа шаардлагатай иргэн гэж бусдын туслалцаагүйгээр өдөр тутмын үйлдлээ бие даан гүйцэтгэх чадваргүй, эсхүл оюуны хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй хүнийг хэлнэ” гэж заасны дагуу эдгээр хүүхдүүдэд эмчилгээ, сувилгаа өдөр тутам шаардлагатайгаас гадна эрүүл мэндийн үйлчилгээ байнга авч байдаг тул байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн санал, гомдол, хэрэгцээ, шаардлагыг үндэслэн дугаарын хязгаарлалтгүй зорчих 2025 оны зөвшөөрлийн бичгийг Замын	2025.01.01 2025.06.30	

					хөдөлгөөний удирдлагын төвтэй хамтран 2025 оны эхний хагас жилд 515 эцэг, эхэд олгоод байна. 2025 оны 01 сарын 10-наас 2025 оны 06 сарын 30-ны хүртэлх хугацаад Замын хөдөлгөөний удирдлагын төв рүү Дугаарын хязгаарлалтгүй зөвшөөрөл авахаар 23 удаа хүсэлт гаргасан албан бичиг илгээсэн.		
2.	<p>Арга хэмжээ 2.</p> <p>Сургуулийн нийгмийн ажилтан, өрхийн эмнэлгийн нийгмийн ажилтан, сургуулийн сэтгэл зүйч нарыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйгээр хангах чадавхжуулах, хүүхдийн төвийн үйл ажиллагаатай танилцуулах.</p> <p>Хамтарч ажиллах байгууллага:ХБХСЗХТ</p>	<p>Арга хэмжээний тоо;</p> <p>Хамрагдах хүний тоо;</p> <p>Удирдамж, сургалтын хөтөлбөр батлуулах,</p>	45	1	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв, Чингэлтэй дүүргийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтэс, Боловсролын хэлтэстэй хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйгээр хангах, чадавхжуулах сургалт”-ыг 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан.</p> <p>Чингэлтэй дүүргийн хамран сургах тойргийн сургуулиудын нийгмийн ажилтнууд, сургуулийн сэтгэл зүйч зэрэг</p> <p>34-н ажилтан, албан хаагчид хамрагдаж,</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог, хэрэгцээ, тохирох хэрэглэгдэхүүн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үнэлэх арга зүй, сайн туршлага, хүүхдийн сөрөг зөн төлөвтэй ажиллах арга зүй зэрэг мэдээллүүдийг хүргэн, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн үйл ажиллагаатай танилцан, туршлага судалж ажилласан.</p>	2025.04.24 2025.05.13	

**Зорилт 2. “ЗГҮАХ-ийн 3.3-р зорилтын 3.3.28-р заалт,
Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 43-р тогтоол, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/109 дугаар тушаал, Боловсрол шинжлэх ухааны яамны сайдын 2021 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн а/177 дугаар тушаал
ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД**

3.	<p>Арга хэмжээ 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах журмын хэрэгжилтийг хангах арга хэмжээ зохион байгуулах</p> <p>Хамтарч ажиллах байгууллага: -Боловсролын ерөнхий газар -ХБХСЗХТ</p>	<p>Арга хэмжээний тоо; Хамрагдсан хүний тоо;</p>	<p>- -</p>	<p>1 45</p>	<p>Боловсролын ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв, Чингэлтэй дүүргийн Боловсролын хэлтэстэй хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулах талаарх мэдээлэл солилцох уулзалт, сургалт”-ыг Чингэлтэй дүүргийн төрийн өмчийн цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч нарт 2025 оны 05 дугаар 13-ны өдөр зохион байгуулсан. Уулзалтад 40 гаруй эрхлэгч, арга зүйч, багш нар хамрагдсан бөгөөд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулах журам”-ын хэрэгжилтийг хангах, дүүргийн СӨБ-ын байгууллагуудын талаарх мэдээлэл, тулгамдаж буй асуудал, тэгш хамруулах боловсролын бодлогын хэрэгжилт, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог, хэрэгцээ, тохирох хэрэглэгдэхүүн, Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт зэрэг мэдээллүүдийг хүргэн, мэдээлэл солилцож ажилласан.</p>	<p>2025.04.20 2025.05.13</p>	
4.	<p>Арга хэмжээ 4. “Тэгш хамруулан хөгжүүлэх” чиглэлээр сургууль, цэцэрлэгийн</p>	<p>Арга хэмжээний тоо;</p>	<p>-</p>	<p>1</p>	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүрийн онцлог хэрэгцээнд нийцсэн дэмжлэг үзүүлж тухайн хүүхдийг үе</p>	<p>2025.05.01 2025.05.09</p>	

	<p>захирал, эрхлэгч нарыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулах</p> <p>Хамтарч ажиллах байгууллага:</p> <p>Боловсролын ерөнхий газар</p>	<p>Хамрагдах хүний тоо;</p> <p>Удирдамж, сургалтын хөтөлбөр батлуулах,</p>		<p>50</p> <p>1</p>	<p>тэнгийн найз нөхөдтэй нь хамт суралцуулах боломжийг бүрдүүлэх, тэгш хамрагдалтыг нэмэгдүүлэх, боловсролын хүртээмж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, хөгжлийн бэрхшээлийн талаарх хандлагыг өөрчлөх зорилгоор ХБХХЕГ, Боловсролын ерөнхий газрын Тэгш хамруулах боловсролын хэлтэс, Дундговь аймгийн Боловсролын газартай хамтран “Боловсролд тэгш хамруулах нь” нөлөөллийн /цахим/ сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр Дундговь аймгийн Ерөнхий боловсролын сургуулиудын захирал, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын эрхлэгч нарт зохион байгууллаа. Нийтдээ 22 сургуулийн захирал, 19-н цэцэрлэгийн эрхлэгч, Дундговь аймгийн Боловсролын газрын мэргэжилтнүүд, Насан туршийн боловсролын арга зүйч, мэргэжилтэн, багш нар зэрэг 50 гаруй хүн хамрагдлаа.</p>		
<p>5.</p>	<p>Арга хэмжээ 5.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өөрт байгаа авьяас, чадвар нөөц боломжид тулгуурлан мэргэжлийн чиг баримжаа олгох, амьдралд бэлтгэх зорилгоор МБУЧОС, тусгай сургуультай хамтран “Мэргэжлээ</p>	<p>Арга хэмжээний тоо;</p> <p>Хамрагдсан хүний тоо;</p> <p>Удирдамж, сургалтын</p>	<p>1</p> <p>100</p>	<p>1</p> <p>100</p>	<p>“Мэргэжлээ зөв сонгоё” өдөрлөгийг 2025 оны 05 дугаар сарын 16-наас 05 дугаар сарын 28-ны хүртэлх өдрүүдэд зохион байгуулсан. Өдөрлөгт ЕБС-ын 25, 29, 70, 116-р сургуулийн төгсөх 9,12 дугаар ангийн 100 гаруй сурагчид хамрагдсан. Арга хэмжээнд мэргэжлээ хэрхэн зөв сонгох,</p>	<p>2025.05.16</p> <p>2025.05.28</p>	

	зөв сонгоё” өдөрлөг зохион байгуулах	хөтөлбөр батлуулах,			мэргэжил сонгох алхамууд, ажил мэргэжлийн ялгаа, мэргэжил эзэмших ач холбогдол, мэргэжлийн чиг баримжаа олгох зэрэг мэдээллүүдийг хүргэж СЗСҮТ-ийн МБУЧОС-ын үйл ажиллагаатай танилцаж ажилласан.		
6.	Арга хэмжээ 6. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын талаарх хууль, дүрэм, журманд санал өгөх	Санал өгсөн баримт бичгийн тоо: 2	1	1	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын талаарх дараах хуулиудад саналаа өгч ажилласан. Үүнд: -Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах -Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад нэмэлт өөрчлөлт оруулах тухай /2025.04.02/	2025.01.02 2025.06.20	
7.	Арга хэмжээ 7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэндийн талаарх амаар болон бичгээр ирүүлсэн өргөдөл, санал, хүсэлт, гомдлыг хүлээн шийдвэрлэх, уламжлах, зөвлөгөө мэдээлэл өгөх	Хүлээн авсан албан бичгийн тоо; Өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн тоо;	-	-	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэндийн талаарх амаар болон бичгээр ирүүлсэн өргөдөл, санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, уламжлах, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Албан хэрэг хөтлөлтийн letter программд 2025 оны эхний хагас жилийн байдлаар 36 мэдээлэл ирсэн. Үүнээс: Ирсэн бичиг-5 Явсан бичиг-24	2025.01.01. 2025.06.30	

					Өргөдөл, гомдол - 7		
					Нийт 7 өргөдөл, гомдлыг шийдвэрлэж 50 гаруй иргэнд зөвлөгөө, мэдээлэл хүргэж ажилласан.		

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Арга хэмжээ 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх Дэмжих төвийн хэрэгжилтийг хангуулж ажиллах.	Арга хэмжээ Хамрах хүрээ	-	1 4	Боловсролын сайд, Эрүүл мэндийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд үзүүлэх чиг үүрэг бүхий дэмжих төвийн дүрэм батлах тухай” А/85, А/55, А/49 хамтарсан тушаал, ГБХНХЯ-ны сайдын 2025 оны 03 сарын 10-ны өдрийн А/64 тушаалын хэрэгжилтийг ханган дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: -Дэмжих төвийн тендерт орох хүсэлтэй байгаа 10-н байгууллагуудын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулсан./2025.04.09./ -Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, хөгжлийн үйлчилгээ үзүүлэх дэмжих төвүүдийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хорооны ажлын хэсгийг байгуулсан./2025.04.08/	2025.01.20 2025.06.30	

					-Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, хөгжлийн үйлчилгээ үзүүлэх дэмжих төвүүдийг сонгон шалгаруулах ХБХХЕГ/20250103003/ дугаар бүхий тендерт шаардлага хангаж, шалгарсан байгууллагуудын гэрээний загварыг боловсруулж ажилласан. /Тендерт 30 гаруй байгууллага материал ирүүлснээс 7 байгууллага шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна./2025.06.05/		
2.	Арга хэмжээ 2. НҮБ-ын хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2023-2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг нэгтгэж Тамгын газарт хүргүүлэх	-	-	-	Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 357 дугаар тогтоолын хавсралт НҮБ-ын хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2023-2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг нэгтгэж ТГ-т хүргүүлсэн./2025.05.29./	2025.05.2 0. 2025.05.2 9	
3.	Арга хэмжээ 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хамгаалах зөвлөл байгуулах	-	-	-	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн хамгаалах зөвлөлийн ажлын хэсгийг байгуулж дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: -2025 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулсан. -Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тулгамдаж буй асуудлуудыг эрэмбэлж гаргасан. /2025.05.20/	2025.05.1 5 2025.05.2 0	
4.	Арга хэмжээ 4. Бодлогын хэрэгжилтийн газрын 2024 оны хагас, бүтэн жилийн гүйцэтгэлийн тайлан, төлөвлөгөөг архивлах	-	-	-	Бодлогын хэрэгжилтийн газрын 2024 оны хагас, бүтэн жилийн гүйцэтгэлийн тайлан, төлөвлөгөөг архивлаж Тамгын газарт хүлээлгэж өгсөн. Үүнд: 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө-1 боть	2025.01.0 1 2025.01.2 0	

					-2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайлан -1 боть -2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлан-1 боть /2025.01.20/		
5.	Арга хэмжээ 5. Нээлттэй хаалганы өдөрлөг	-	-	-	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын нээлттэй өдөрлөгт оролцож нийтдээ 13 иргэнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн халамж асрамж, 10 иргэнд хөгжлийн бэрхшээлтэй хүний байнгын асаргаа, 2 иргэнд боловсролын зээлийн талаар, 3 иргэнд эрүүл мэндийн талаар тус тус зөвлөгөө мэдээлэл хүргэж ажилласан. /2025.05.15/	2025.05.10 2025.05.15	

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Эрхлэх асуудлын чиглэлээр холбогдох байгууллагаас зохион байгуулж танхимын болон цахим сургалт, семинарт хамрагдах 1-с доошгүй сургалт/семинарт хамрагдах	1-с доошгүй сургалт/семинарт хамрагдах	2 удаа	2 удаа	-Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт /2025.01.20. 2025.05.24/ -Монгол бичгийн анхан, дунд шатны сургалт/2025.05.21-06.04/ -Эрт үеийн боловсрол ба сонсголгүйн боловсрол сургалт /2025.06.04./ -Сонсголгүйн соёл ба дохионы хэлний ойлголт /2025.06.09./	2025.01.01. 2025.06.01	

2.	Арга хэмжээ 2. Хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх Тодорхой хууль тогтоомжийг судалж үйл ажиллагаандаа ашигласан байх	-	-	Удирдлагын академийн ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалтад хамрагдаж хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэн тодорхой хууль тогтоомжийг судалж үйл ажиллагаандаа ашиглан ажиллаж байна. 2025.01.20.	2025.01.01 2025.01.20	
----	--	---	---	--	--------------------------	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн
хамгааллын асуудал хариуцсан
мэргэжилтэн
(Албан тушаал)

Г.Сүрэнцэцэг
..... /Г.Сүрэнцэцэг/

(Нэр, гарын үсэг)

2025.06.10.

(Огноо)